

ХЭРЭГЛЭГЧДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ДҮН


Түүвэр судалгаанд Улаанбаатар хотын 9 дүүргийн 135 хорооноос 1023 иргэдийг санамсаргүй түүврийн аргачлалаар сонгож хамрууллаа. Судалгааны үр дүнгээр иргэдийн инфляцийн хүлээлт 2011 оны эцэст **10.9%**, 2012 оны 3-р улирлын эцэст буюу жилийн дараа **10.0%** байхаар хүлээгдэж байна. Мөн үнийн өсөлтийг тодорхой тоон заагаас асуухад иргэдийн инфляцийн хүлээлт жилийн дараа **10.2%** байхаар хүлээгдэж байна.

1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

- Насны бүтцийг харвал судалгаанд оролцогчдын 50.5% нь 25-44 насны;
- Боловсролын түвшингээр авч үзвэл 88.6% нь бүрэн дунд болон дээд боловсролтой;
- Ам бүлийн тоог харвал нийт судалгаанд оролцогчдын 81.8% нь 2-5 ам бүлтэй;
- Ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл 47.9% нь хувийн салбарт ажилладаг, 17.7% нь төрийн албанд, 24.0% нь ажилгүй;
- Өрхийн орлогын зүгээс харвал 56.0% нь 200-400 мянган төгрөгийн орлоготой, 17.8% нь 200 мянгаас бага, 14.9% нь 600-800 мянга, 11.3% нь 800 мянган төгрөгөөс дээш орлоготой өрхүүд байлаа.¹

Зураг 1 Ирэх 12 сарын хугацаанд үнийн түвшин хэрхэн өөрчлөгдөх вэ?


- 1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө
- 2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй
- 3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна
- 4. Үнэ өөрчлөгдөхгүй
- 5. Үнэ буурна
- 6. Мэдэхгүй



Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа 2011 оны 9 сар

Зураг 2 Ирэх 3 сарын хугацаанд бараа, бүтээгдэхүүний үнэ одоогийнхтой харьцуулахад хэрхэн өөрчлөгдөх вэ?

- 1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө
- 2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй
- 3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна
- 4. Үнэ өөрчлөгдөхгүй
- 5. Үнэ буурна
- 6. Мэдэхгүй



Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа 2011 оны 9 сар

1. Хүлээлтийн түвшин /чанарын хариулт/

2011 оны 3-р улиралд явуулсан судалгаагаар нийт иргэдийн **75%** нь ирэх 12 сарын хугацаанд үнийн түвшин **ерөнхийдөө өснө** гэж үзсэн нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад бага зэрэг буурсан үзүүлэлт байна /Зураг 1/.

Үүнээс иргэдийн 31% нь одоогийн инфляцийн түвшнээс илүү хурдацтайгаар, 29% нь одоогийнхтой ижил түвшинд, 14% нь одоогийнхоос бага хэмжээгээр өснө гэжээ.

Харин судалгаанд оролцогчдын 4% нь үнэ өөрчлөгдөхгүй, 2% нь буурна гэж үзэж байна. Иргэдийн 18% нь мэдэхгүй гэж хариуллаа.

Түүнчлэн иргэдийн **78%** нь ирэх 3 сарын хугацаанд үнийн түвшин ерөнхийдөө өснө гэж үзэж байгаа нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад мөн л бага зэрэг буурсан байна /Зураг 2/.


Үүнээс 29% нь одоогийн инфляцийн түвшнээс илүү хурдацтайгаар өснө гэж хариулсан нь өмнөх судалгааны дүнгүүдтэй харьцуулахад хамгийн бага түвшинд очсон байна. Харин 37% нь одоогийнхтой адил түвшинд, 16% нь одоогийнхоос бага

¹ Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 1 – ээс харна уу.

хэмжээгээр өснө гэж үзжээ. 5% нь үнэ өөрчлөгдөхгүй, 1% нь буурна гэж үзсэн бол 14% нь мэдэхгүй гэжээ.

Дээрх чанарын хариултуудыг Карлсон-Паркин нарын магадлалын аргаар² тоон утгад хөрвүүлэн тооцвол иргэд 2011 оны эцэст жилийн инфляци **10.9%**, 2012 оны 3-р улирлын эцэст **10.0%**-д хүрнэ гэж хүлээж байна.

Зураг 3 Хүлээлтийн чиглэлийн индекс, жилийн хүлээлт, инфляци



Санамж: Чиглэлийн индекс нь (-1;3) завсарт утгаа авна. Нэмэх чиглэл руу хүлээлтийн хандлага өссөн, хасах чиглэл руу инфляцийн хүлээлтийн хандлага буурсан байгааг илтгэнэ.

авбал үнийн түвшин одоогийнхоос бага зэрэг өсөх буюу иргэдийн ихэнхи нь одоогийн үнийн өсөлтөөс багаар өснө гэсэн хандлагатай байгааг илтгэнэ. Харин [0] дээр утга авбал үнэ өсөхгүй яг одоогийн түвшинд байна гэж үзсэнийг, [0;-1] засварт утга авсан тохиолдолд иргэд үнэ буурна гэсэн хандлагатай байгааг харуулж байгаа юм.

Чиглэлийн индекс 2011 оны 1 болон 6 саруудад улаан муж руу нэвтэрсэн нь тухайн хугацаанд иргэд 12 сарын дараа үнийн түвшин хурдацтай өснө гэж үзэх хандлагатай байсныг илтгэж байна. Харин судалгааг явуулсан бусад хугацаанд индекс шар мужид утгаа авч байсан нь иргэд үнийн түвшин одоогийнхтой адил түвшинд өснө гэж үзэх хандлагатай байсныг харуулна. Хамгийн сүүлд буюу 2011 оны 9 сард өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад иргэдийн хүлээлтийн хандлага бага зэрэг буурч чиглэлийн индекс шар мужид очсон байна.

Иргэдийн хүлээлтийн түвшин² –г тухайн үеийн инфляцийн түвшинтэй харьцуулбал 2009 оны 9 сар, 2010 оны 1 сар, 2011 оны 3 болон 6 сарын судалгааны дүнгээр тухайн үеийн инфляцийн түвшингээс дээгүүр байсан бол бусад үеүүдэд тухайн үеийн инфляциас доогуур түвшинд очсон байна. Энэ удаагийн буюу 9-р сарын судалгааны дүнгээр инфляцийн хүлээлт одоогийн түвшингээс буурч, жилийн дараа инфляци 10.0% болохоор хүлээгдэж байна.

Чиглэлийн индексийн хөдөлгөөнийг хүлээлтийн түвшинтэй харьцуулж харвал 2008 оноос 2010 оны 1 сар хүртэлх судалгааны дүнгээр эсрэг чиглэлтэй буюу чиглэлийн индекс өсөх хандлагатай байхад хүлээлт буурах чиглэлтэй байна. Энэ нь дэлхийн санхүү, эдийн засгийн хямралтай холбоотойгоор инфляцийн түвшин огцом буурснаас шалтгаалж хүлээлтийн түвшинг буурахад нөлөөлжээ. Учир нь хүлээлтийн түвшингийн чанарын хариултыг тоон утга руу хөрвүүлэхэд инфляцийн түвшинг оруулж тооцдог тул инфляци буурсан тохиолдолд хүлээлтийн тоон утга мөн буурч гарна. Мөн 2011 оны 6

2. Ерөнхий хандлага

Иргэдийн 12 сарын дараах үнийн өсөлтийн хүлээлтийг тандсан чанарын хариултаар **Хүлээлтийн чиглэлийн индекс**³-ийг тооцлоо /Зураг 3/.


Хэрэв чиглэлийн индекс нь **улаан муж** буюу [2;3] завсарт утга авбал иргэдийн хүлээлт хурдацтай өсөх аюулын дохио өгч байгаа буюу иргэдийн дийлэнх нь үнэ маш хурдацтайгаар өснө гэсэн хандлагатай байгааг харуулна. Хэрэв **шар муж** буюу [1;2] завсарт утга авбал үнэ одоогийн өсөлтийн түвшиндээ байна буюу иргэдийн ихэнх нь үнэ ерөнхийдөө өснө гэсэн хандлагатай байгааг, харин цагаан муж буюу [0;1] завсарт утга

² Carlson, John A. and Parkin, Michael /1975/: Inflation expectations. "Econometrica" 42, pp. 123-38. Карлсон-Паркин нарын хүлээгдэж буй инфляцийг тооцох тооцоололд өнөөдрийн инфляциар өмнөх 12 сарын дундаж жилийн инфляцийн түвшинг ашиглалаа.

³ Hannah Nielsen /2003/: Inflation Expectations in the EU – Results from Survey data, pp. 10-11.

сарын судалгааны дүнгээр иргэдийн хүлээлтийн хандлага өссөн ч хүлээлтийн тоон утга буурсныг, инфляцийн түвшин буурснаар тайлбарлаж болно.

Зураг 4 Инфляци ба 2011 оны жилийн эцсийн ХҮЛЭЭЛТ




Эх сурвалж: Монголбанк, Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа
УСХ, Сарын мэдээ

3. Жилийн эцсийн инфляцийн хүлээлт

2010 оны эцэст инфляцийн түвшин хоёр оронтой тоонд буюу 14.3%-д хүрсэн ч 2-р улиралд огцом буурч 5.5 хувь болжээ. Харин 2011 оны 9 сарын байдлаар жилийн инфляци бага зэрэг өсч 11.9% -тай байна. 2011 оны эхэнд явуулсан судалгаагаар иргэд инфляцийн түвшинг жилийн эцэст **13.6%** байхаар хүлээж байсан бол 3-р улирлын эцсийн судалгааны дүнгээр **10.9%** болж буурчээ. Оны эхний иргэдийн хүлээлт одоогийн инфляциас өндөр байгаа нь тухайн үед үнийн түвшин нэлээдгүй өндөр байсан болон олон нийтэд зарлаж байсан инфляцийн таамаглалууд⁴ харьцангуй өндөр байсан нь нөлөөлсөн байж болох юм.

Нөгөө талаас иргэдийн үнэ өснө гэсэн хандлага өндөр байсан. Хэдийгээр инфляци хагас жилээс бага зэрэг өссөн хэдий ч иргэдийн үнэ өснө гэсэн хандлага буурсан учраас иргэд инфляцийг энэ оны эцсээр одоогийн түвшнээс буурна гэж үзжээ.

Зураг 5 Хүлээлтийн түвшин, тоон хариулт /ирэх 12 сарын хугацаанд/




Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа 2011 оны 9 сар

4. Хүлээлтийн түвшин /тоон хариулт/

Иргэдийн 12 сарын дараах хүлээлтийн түвшинг тодорхой тоон завсраас асуух замаар тооцоолол хийлээ. Зураг 1.5-аас харахад судалгаанд оролцсон иргэдийн 34% нь инфляцийг 12 сарын дараа 9-11%-д, 19% нь 11-13%-д, мөн 16% нь 7-9%-д байна гэж үзжээ. Иргэдийн инфляцийн хүлээж буй дундаж утга **10.2%** байна /Зураг 5/.

⁴ ОУВС, Дэлхийн Банк, Монголбанкны албан

Зураг 6 Таны бодлоор ирэх 12 сарын хугацаанд банкны зээлийн хүү хэрхэн өөрчлөгдөх вэ?



Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа


5. Бусад асуултуудын дүн

Судалгаанд оролцсон иргэдийн 26% нь **зээлийн хүү өснө** гэж хариулсан нь өмнөх судалгаанаас 2 нэгжээр, 2011 оны 1 сарын түүвэр судалгаанаас 8 нэгжээр тус тус өссөн үзүүлэлт байна. Харин 2008 оныхтой харьцуулахад 9 нэгжээр буурсан байна /Зураг 6/.

Харин **зээлийн хүү хэвэндээ** байна гэсэн дүн 31%-д хүрч өмнөх судалгааны дүнгээс өөрчлөгдөөгүй байна. **Зээлийн хүү буурна** гэж иргэдийн 16.7% нь хариулсан нь өмнөх судалгааны дүнгээс 8 нэгжээр буурсан байна. 2011 оны 2-р улиралд буурч нэг оронтой тоонд хүрээд байсан инфляцийн түвшин оны 2-р хагасаас эхлэн огцом өсч 2 оронтой тоонд хүрсэн нь иргэдийн зээлийн хүү өснө гэсэн хүлээлтийг нэмэгдүүлсэн байж болно.


Иргэдийн зээлийн хүүний талаарх хандлагын чиглэлийн индексийг харвал 2008 оноос 2010 оны 7 сарын судалгааны дүнгээр иргэд ирэх 12 сард зээлийн хүү одоогийнхоос ерөнхийдөө өснө гэсэн хандлагатай байсан боловч уг хандлага нь бага багаар буурсаар 2011 оны 1 сарын судалгааны дүнгээр хэвэндээ байна гэж үзсэн бол 3-р сард зээлийн хүүг буурна гэсэн хандлагатай болжээ. Харин 6-р сараас эхлэн зээлийн хүүний хандлага өсч 9 –р сарын судалгаагаар иргэдийн дийлэнх нь ирэх 12 сард зээлийн хүүг одоогийнхоос өснө гэж үзсэн байна. Эндээс иргэдийн зээлийн хүүний хандлага тухайн үеийн зээлийн хүүний хөдөлгөөнтэй ижил чиглэлтэй нь харагдаж байна /Зураг 6.а/

Зураг 6.а Зээлийн хүүний чиглэлийн индекс ба зээлийн хүү



Санамж: Чиглэлийн индекс нь [-1;1] завсарт утгаа авна. [0;1] завсарт утгаа авбал хүү өснө, [0] дээр утга авбал хэвэндээ байна, [0;-1] завсарт утгаа авбал буурна гэсэн утгыг илэрхийлнэ.

Зураг 7 Таны бодлоор ирэх 12 сард төгрөгийн ханш хэрхэн өөрчлөгдөх вэ?




Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

Төгрөгийн бусад валюттай харьцах ханшийг **чангарна** гэж үзсэн иргэдийн хувь 2011 оны 1 сарын түүвэр судалгаанаас тогтмол буурсаар 23.1%-д хүрсэн бол **хэвэндээ байна** гэсэн хариулт хамгийн өндөр түвшиндээ хүрч 49.3% болжээ. Харин **суларна** гэж үзсэн иргэдийн хувь 27.7 хувьд хүрч өмнөх судалгааны дүнгээс 4 нэгжээр буурсан байна. Сүүлийн жилүүдэд манай улсад эрчимтэй орж буй хөрөнгийн урсгалаас шалтгаалан төгрөгийн гадаад валюттай харьцах ханш аажмаар чангарсаар 2011 оны 8-р сарын дундаж ханш

өмнөх сартай харьцуулахад 0.6%-иар, өмнөх оны мөн үеэс 6.5%-иар тус тус чангарсан боловч судалгаанд оролцогчдын 2 хүн тутмын нэг нь төгрөгийн ханш хэвэндээ байна гэж үзсэн байна /Зураг 7/.


Зураг 7.а Төгрөгийн ханшийн чиглэлийн индекс



Санамж: Чиглэлийн индекс нь [-1;1] завсарт утгаа авна. [0;1] завсарт утгаа авбал ханш өснө, [0] дээр утга авбал хэвэндээ байна, [0;-1] завсарт утгаа авбал чангарна гэсэн утгыг илэрхийлнэ.

Иргэдийн төгрөгийн ханшийн хандлагын чиглэлийн индексийг харвал иргэд 2011 оны эхэнд хийсэн судалгаагаар ханш ирэх 12 сард чангарна гэж үзэж байсан бол 3 сард энэ хандлага бага зэрэг буурч, 6 сарын судалгаагаар төгрөгийн ханшийг хэвэндээ байна гэж үзжээ. Харин 9-р сарын судалгаагаар иргэд ирэх 12 сард төгрөгийн ханш чангарна гэж үзсэн байна /Зураг 7.а/.

Зураг 8 Таны бодлоор ирэх 12 сард хадгаламжинд мөнгө хийхэд тохиромжтой үе мөн үү?




Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

Судалгаанд оролцогчдын 23 хувь нь **хадгаламжинд мөнгө хийхэд тохиромжтой** үе гэж үзэж байгаа нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад бага зэрэг өсч, **тохиромжгүй** гэсэн хариулт буурч 27 хувьд хүрээд байна. Харин тал хувь нь **мэдэхгүй** гэж үзсэн нь өндөр хэвээр байна.

2011 оны 7-р сарын эцсийн байдлаар хадгаламжийн бодит хүү сөрөг болсон ч 8 сард эерэг⁵ түвшинд очсон бөгөөд төгрөгийн хадгаламж өсөх⁶ хандлага үргэлжилсээр байгаа нь судалгааны хадгаламж хийхэд тохиромжтой үе мөн гэсэн хариултын хувь нэмэгдсэнтэй нийцэж байна /Зураг 8/.

Зураг 9 Танай өрхийн санхүүгийн байдал ирэх 12 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдөх вэ?




Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

Ирэх 12 сарын хугацаанд иргэдийн өрхийн **санхүүгийн байдал сайжирна** гэж судалгаанд оролцогчдын 30% гаруй нь үзсэн нь өмнөх судалгааны дүнгүүдээс өсч хамгийн өндөр түвшиндээ хүрлээ. Гэсэн хэдий ч **муудна, хэвэндээ байна** гэсэн иргэдийн хувь 48%-д байгаа нь өндөр хэвээр байна /Зураг 9/.

⁵ 2011 оны 8 сарын эцсийн байдлаар хадгаламжийн жигнэсэн дундаж хүүнээс инфляцийн түвшинг хасаж тооцсон бодит хүү 0.5% байна.

⁶ 2011 оны 8 сарын эцсийн байдлаар төгрөгийн хадгаламж жилийн 73.0 хувийн өсөлттэй байна.


Зураг 9.а Өрхийн санхүүгийн байдал



Санамж: Чиглэлийн индекс нь [-1;1] завсарт утгаа авна. [0;1] завсарт утгаа авбал өрхийн санхүүгийн байдал өснө, [0] дээр утгаа авбал хэвэндээ байна, [0;-1] муудна гэсэн утгыг илэрхийлнэ.

2008 оны эцэст хийгдсэн судалгааны дүнгээр иргэдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд өрхийн санхүүгийн байдал нь муудна гэж үзэх хандлагатай байсан бол 2009 оны 9-р сараас хойш хийгдсэн судалгаануудаар ирэх 12 сард ерөнхийдөө сайжирна гэж үзэх хандлагатай болсон байна. Чиглэлийн индекс 2011 оны эхнээс тогтмол өссөөр байгаагаас харвал иргэд ирээдүйд санхүүгийн байдал нь сайжирна гэсэн хандлага нэмэгдсээр байгааг харуулж байна /Зураг 9.а/.


Зураг 9.б Сайжрах бол шалтгаан нь юу вэ?



Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

Өрхийн санхүүгийн байдал **сайжирна** гэж судалгаанд оролцсон иргэдийн 30% нь хариулсан бөгөөд тэдгээрийн 51.0% нь ирэх 12 сард цалин болон бизнесийн орлого нэмэгдэнэ гэж үзсэн байна. 17.7% нь гэр бүлийн гишүүдээс ажлын байртай болно гэсэн бол 9.4% төрөөс тэтгэмж, тэтгэлэг авснаар өрхийн санхүү дээшилнэ гэж үзсэн байна. Харин 8.0% нь үл хөдлөх хөрөнгийн үнэ өссөнөөс, 7.8% нь үнэ буурснаар өрхийн санхүү дээшилнэ гэжээ. Татварын хөнгөлөлт хүртэнэ, бусдаас тусламж авна гэсэн хариултын харьцангуй бага байна /Зураг 9.б/.

Зураг 9.в Муудах бол шалтгаан нь юу вэ?



Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

Өрхийн санхүүгийн байдал **муудна** гэж иргэдийн 16% нь хариулсан бөгөөд тэдгээрийн 46% нь ирэх 12 сарын хугацаанд үнэ өссөнөөс шалтгаална гэжээ. Харин 23.5% нь цалин болон бизнесийн орлого буурна, 10% нь өрхийн гишүүн ажилгүй болно, 8.5% нь үл хөдлөх хөрөнгийн үнэ буурна, 4% нь төрөөс тэтгэмж тэтгэлэг авахгүйн улмаас санхүүгийн байдал доройтно гэсэн хариултыг өгчээ /Зураг 9.в/.

ДҮГНЭЛТ

Санал асуулгын дүнгээр иргэдийн дийлэнх хувь нь ирэх нэг жилийн дараа үнийн түвшинг ерөнхийдөө өснө гэж хүлээж байгаа бөгөөд харин ердөө 2% нь буурна гэж үзжээ. Эдгээр чанарын хариултуудыг тоон утгад хөрвүүлбэл жилийн дараах иргэдийн хүлээлт 10.0%-д хүрч, өнөөдрийн инфляцийн түвшингээс бага зэрэг буурхаар байна.

Жилийн эцсийн инфляцийн хүлээлтийг харвал 2011 оны эхээр явуулсан судалгааны дүнгээр иргэдийн хүлээлт 2011 оны эцэст одоогийн инфляцийн түвшингээс өсч 13.6% байхаар хүлээгдэж байсан бөгөөд тоон утгаар асуухад дунджаар 12.1% байхаар хүлээгдэж байсан. Харин энэ удаагийн буюу 9 сарын судалгааны дүнгээр иргэдийн хүлээлт жилийн эцэст одоогийн инфляцийн түвшингээс буурч 10.9% байхаар хүлээгдэж байна.

Иргэдийн инфляцийн хүлээлтийн чиглэлийн индексийг тооцож харахад 2011 оны эхнээс иргэдийн хүлээлт огцом нэмэгдэж 6-р сарын байдлаар хамгийн өндөр түвшиндээ хүрсэн бөгөөд чиглэлийн индекс улаан муж руу буюу хүлээлт хурдацтай өсөх аюултай дохио өгч буй мужид очсон байна. Харин энэ удаагийн судалгаагаар чиглэлийн индекс 6-р сарын дүнгээс буурч улаанаас шар мужид буюу үнэ хурдацтай өснө гэсэн хүлээлтийн хандлага буурч үнийн өсөлт одоогийн түвшиндээ байна гэсэн хандлагатай болсон байна.

Бусад асуултуудын дүнгээр иргэдийн ихэнх нь ирэх 12 сард зээлийн хүү одоогийн түвшнээс бага зэрэг өснө гэж үзсэн байна. Хадгаламжинд мөнгөө байршуулахад тохиромжтой гэж үзсэн иргэдийн тоо бага зэргээр өсч, тохиромжгүй гэж үзсэн иргэдийн тоо буурчээ. Өмнөх судалгааны дүнгээр иргэдийн төгрөгийн ханшийн хүлээлтийн хандлага ирэх 12 сарын хугацаанд хэвэндээ байхаар хүлээгдэж байсан бол энэ удаагийн судалгаагаар одоогийнхоос бага зэрэг суларна гэсэн хандлагатай байна. Харин өрхийн санхүүгийн байдлын талаар асуухад ирэх 12 сард санхүүгийн байдал нь одоогийнхоос сайжирна гэсэн хүлээлтийн хандлага бага зэрэг давамгайлсан бөгөөд тэдгээрийн тал нь цалин болон бизнесийн орлого нь нэмэгдсэнээс өрхийн санхүү сайжирна гэж үзжээ. Харин муудна гэж иргэдийн 16% нь үзсэнээс дийлэнх нь үнэ өссөнөөс мөн цалин болон бизнесийн орлого буурснаас өрхийн санхүү муудна гэж үзжээ.